



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 07 өдөр

Дугаар А/371

Хэрлэн сум

Буриад түмний урлаг, спортын
“Алтаргана-2022” Олон улсын их наадамд
оролцоход хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.21, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2, 14.2.3, Соёлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 06 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.5.6.4 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Оросын Холбооны Улсын Агын Буриадын Автономит тойрогт 7 дугаар сард зохион байгуулагдах “Алтаргана-2022” олон улсын урлаг спортын их наадамд оролцоход шаардагдах зардалд 17,566,040 (арван долоон сая таван зуун жаран зургаан мянга дөчин) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх “Хэнтийн түүх- бидэнд чухал” арга хэмжээний зардлаас 10,000,000 (арван сая) төгрөг, Засаг даргын нөөц сангийн байгууллага, иргэдээс тавьсан санал хүсэлтийг шийдвэрлэх зардалаас 7,566,040 (долоон сая таван зуун жаран зургаан мянга дөчин) төгрөгийг тус тус санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Нямдаваа)-д гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

231010831

Аймгийн Засаг даргын 2022
онь... дугаар сарын...-ны
захирамжийн хавсралт

АЛТАРГАНА-2022"
ИХ НААДМЫН ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Хэмжих нэгж	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ	Тайлбар
1	Засаг даргын мэндчилгээ	ш	1	35,000	35,000	Хэвлүүлэх
2	Нутгийн брэнд	ш	9	30,000	270,000	
3	Гарын бэлэг	ш	15	45,000	675,000	
4	Жолооч нарын албан томилолт	хоног	3	112,000	336,000	Чингис - Эрхүү - Чингис /28000төг*4хоног=112000 төг/
5	Шатахууны зардал (автобус)	л	528	5,000	2,640,000	100км-44л гэж үзээд ирж очих 1200км
6	Шатахууны зардал (делика)	л	216	3,420	738,720	100км-18л гэж үзээд ирж очих 1200км
7	Шатахууны зардал (старикс)	л	216	3,420	738,720	100км-18л гэж үзээд ирж очих 1200км
8	Хоолны зардал	ш	61	90,000	5,490,000	1 хүний хоол өдрийн 15.000 төгрөг, 5 хоногоор тооцов
9	Зочид буудлын зардал	ш	61	96,600	5,892,600	1 хүн 350рубль, 1рубль*69₮=24150₮, Хаан банкны ханш /4 хоногоор/
10	Гадаад оронд зорчих хугацааны тээврийн хэрэгслийн даатгал (автобус)	ш	3	250,000	750,000	
НИЙТ					17,566,040	